

1. Зохиолын дүрийг нэрлэнэ үү.

.....,

2. Дүрийг хэлсэн үгтэй нь зөв харгалзуулаарай.

1. Шарбаатар
2. Насан хатан
3. Монголжин
4. Хиа

А. Миний хатнаас голомт залгах хүү төрвөл халхтай байлдахыг зогсооно.

Б. Өршөө намайг! Ах дүү нарынхаа цусыг урсгасан аян дайны явдалд алжаан сульдлаа би.

В. Таны залуу хатан Насан ахайтан гэж түргэн хариулаад, өршөөл эрсэн хүлцэнгүй харцаар нүд цавчилгүй ширтэв.

Г. –Юу гэсэн үг вэ? Эзэн чинь мэдчихвэл...

3. Тодорхойлолтыг гүйцээж бичнэ үү.

Хэмжээ болоод дүрийн хувьд өгүүллэгтэй ойр боловч ихэнхдээ амаар дамжиж яригдаж ирсэн ер бишийн үйл явдал, гэнэтийн онцгой сонин учрал тохиолыг үзүүлсэн, хурц зөрчил, санаанд оромгүй уран шийдэлтэй зохиолыг гэнэ.

А. Домог Б. Туурь В. Өгүүллэг Г. Шүлэг

4. Зохиолын үйл явдлыг зөв дараалалд оруулаарай.

- 1.
- 2.
- 3.
- 4.
- 5.
- 6.
- 7.

1. Шарбаатарын хатан Насан охин төрүүлж, олзны бүсгүй хүү төрүүлэв.

2. Халх Ойрадын дайн ширүүссэн цаг үе.

3. Ойрадын жанжин "Олзны хатнаас охин төрвөл өршөөнө. Хүү төрвөл дор нь ална. Миний хатнаас голомт залгах хүү төрвөл Халхтай байлдахыг зогсооно." гэж зарлиг буулгасан.

4. Насан хатны сүүлчийн гуйлт

5. Насан хатан Монголжинд охиноо өгч, Монголжин хүүгээ зөрүүлэв.

6. Сүүн цагаан туяа орчлонг гийгүүлэн мандав.

7. Шарбаатар тунхаглан зарлав.

